

БАЯН-ӨНДӨР СУМЫН “ИРГЭДИЙН САНААЧЛАГЫГ ДЭМЖИХ” ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1 Төр иргэний хамтран ажиллах үйл ажиллагааг бэхжүүлэх, иргэдийн гаргасан санал санаачилгыг дэмжин ажиллах, ажлын зардлыг санхүүжүүлж, гүйцэтгэлийг тайлагнахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1 Хөтөлбөрийн зорилго:

2.1.1 Иргэдийн ая тухтай, сэтгэл ханамжтай, аюулгүй амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, иргэн төвтэй төрийн үйлчилгээг бий болгох

2.2 Хөтөлбөрийн зорилт:

2.2.1 Иргэдийн санаачилга, оролцооны талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, дэмжих ажлыг таниулан сурталчлах, иргэдэд мэдээ мэдээлэл өгөх, арга туршлагыг сайжруулах

2.2.2 Төр, иргэдийн хоорондын уялдаа холбоог сайжруулж иргэд, олон нийтийн идэвхтэй оролцоог хангах

2.2.3 Иргэдийн санаачилга, оролцоогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлэх

2.2.4 Иргэдийн санал санаачилгаар дамжуулан нийгмийн эерэг хандлагыг бий болгох

2.2.5 Нийтийн сайн сайхны төлөө хүн бүрийн оролцоог хангах

Гурав. Хэрэгжүүлэх зарчим, хугацаа, хамрах хүрээ

3.1 Хөтөлбөрийн зарчим:

3.1.1 Хариуцлагатай, ил тод байх

3.1.2 Тэгш хүртээмжтэй байх

3.1.3 Нийтийн эрх ашиг зөрчигдөхгүй байх

3.1.4 Хувийн ашиг сонирхлоос ангид байх

3.2 Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа:

3.2.1 Хөтөлбөр батлагдсан өдрөөс эхлэн 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

3.3 Хөтөлбөрийн хамрах хүрээ:

3.3.1 Баян-Өндөр сумын нийт иргэд.

Дөрөв. Ажил гүйцэтгэх

4.1 Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газраас томилогдсон ажлын хэсэг иргэдийн ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх боломжтой эсэхийг судалж холбогдох байгууллагуудын нөөц болон чадамжийг тодорхойлж Засаг даргын зөвлөлд танилцуулж шийдвэрлэнэ.

4.2 Иргэдийн ирүүлсэн хүсэлт нь ажлын хүрэх үр дүн тодорхой, нийтийн эрх ашгийг хангасан байна. Нэмэлтээр техник, тоног төхөөрөмж, эд материал, шаардлагатай тохиолдолд шатахууны тооцооллыг хавсаргаж өгнө.

4.3 Иргэн ажил гүйцэтгэхээс өмнөх ба дараах зургийг авч баримтжуулсан байна.

4.4 Тоног, төхөөрөмжийг ашиглах тохиолдолд хариуцлагын гурвалсан гэрээг байгуулна.

4.5 Дэмжлэг нь 5,000,000.00 хүртэлх төгрөгийн өртөгтэй байна.

4.6 Иргэнд олгох дэмжлэгт цалин, урамшуулал олгогдохгүй зөвхөн сайн дурын үндсэн дээр ажлыг хийж гүйцэтгэнэ.

4.7 Хөтөлбөрийг иргэдэд сурталчлан таниулах ажлын зардлыг тус хөтөлбөрөөс санхүүжүүлнэ.

Тав. Хүрэх үр дүн

5.1 Иргэдийн санаачилгыг дэмжсэнээр иргэдийн оролцоот үйл ажиллагааг зохион байгуулах арга барилыг сайжруулан, эрхээ эдэлж, үүрэг, хариуцлагаа ухамсарлан орон нутгийн хөгжилд өөрийн санал санаачилгыг оруулж, төсөл хөтөлбөрт хамрагдаж, төр ба иргэний харилцаа холбоог бэхжүүлснээр иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэн, амьдрах хүрээлэн буй орчны нөхцөл байдал сайжирсан байна.

Зургаа. Хориглох заалт

6.1 Тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар гүйцэтгүүлэх, хүн амь нас эрүүл, мэндэд хохирол учруулж болзошгүй санал санаачилгыг хүлээж авахгүй байх.

6.2 Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн орцны засвар болон хувь хүний эзэмшлийн бүсэд санхүүжилт хийхийг хориглоно.

Долоо. Хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх

7.1 Иргэдийн санаачилгыг дэмжих хөтөлбөр нь жил бүрийн Байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй хавсран Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст давхар хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдэнэ.

7.2 Хөтөлбөрийн үр дүн санхүүгийн тайлан мэдээллийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн жилийн эцсийн хэрэгжилтийн тайлантай хамтатган сумын ИТХ-д тайлагнана.

Найм. Санхүүжилт

8.1 Хөтөлбөрийг тухайн жил Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан батлагдсан төсвөөр санхүүжүүлнэ.

8.2 Хэрэгжүүлж буй арга хэмжээ, төслийн санхүүжилтийг 80 хувийг ажил эхлэхэд олгох бөгөөд үлдэгдэл санхүүжилт болох 20 хувийг ажил гүйцэтгэсний дараа олгоно.

Ес. Хөрөнгийн тайлагнал, хяналт тавих

9.1 Хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, тухайн шатны Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

9.2 Хөрөнгийн зарцуулалтын тайланг санхүүжүүлсэн зардал, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөвтэй зэрэгцүүлэн гаргаж, байгууллагын дарга, нягтлан бодогч нар гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулан холбогдох баримтыг хавсаргана.

9.3 Хөрөнгийн зарцуулалт, тайлагналыг тухайн шатны Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч хариуцан гүйцэтгэнэ.

9.4 Тухайн шатны Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн нэгж нөөц хөрөнгийн зарцуулалт, эх үүсвэрийн үлдэгдлийн талаарх мэдээллийг Засаг даргын зөвлөлийн хуралд улирал бүр танилцуулна.

9.5 Хөрөнгийн зарцуулалтад санхүү, төрийн сангийн нэгж, төсвийн захирагч тус тус хяналт тавина.

Арав . Хариуцлага

10.1 Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлж, хууль зөрчихгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах үүргийг ажлын хэсэг энэхүү журмаар хүлээнэ.

10.2 Энэ журмыг зөрчсөн байгууллага, иргэн, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

